# НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 01 сарын 03 өдөр Дугаар А/03 Улаанбаатар хот

Олон улсын өсвөрийн
сагсан бөмбөгчдийн тэмцээн
зохион байгуулах тухай

Монгол Улсын Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйл, Засгийн газрын 2009 оны 05 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн 2014 оны зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Ах дүү хотуудын ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын сагсан бөмбөгийн 10 дахь удаагийн тэмцээнийг 2014 оны 01 дүгээр сарын 06-10-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулсугай.

2.. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

3. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 792.800 /долоон зуун ерэн хоёр мянга найман зуу/ төгрөгийг нийслэлийн орон нутгийн төсвөөс хуваарилсан нийтийн биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн арга хэмжээний зардлаас гаргахыг нягтлан бодогч О.Эрдэнэцэцэгт зөвшөөрсүгэй.

4. Тэмцээний урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж, зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг ахлах мэргэжилтэн А.Болдмаад үүрэг болгосугай.

ДАРГА Ж.ГАНБОЛД

Tushaal 2014

1150500005

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын даргын
2014 оны ..нэгдүгээр.. сарын ..03-ны өдрийн
..А/03.. дугаар тушаалын хавсралт

Олон улсын өсвөрийн
сагсан бөмбөгчдийн
тэмцээний төсөв

| № | Зардлын нэр | Нийт дүн |
|---|---|---|
| 1. | Багийн шагнал:<br>1-р байр 60.000 төг<br>2-р байр 50.000 төг<br>3-р байр 40.000 төг | 150.000 |
| 2. | Өргөмжлөл<br>/5 х 20.000 төг/ | 100.000 |
| **ДҮН:** | | **250.000 төг** |

Боловсруулсан А.Болдмаа
Хянасан О.Эрдэнэцэцэг